

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ

PROBLEMS OF ENSURING SECURITY IN THE POSSESSION OF SOCIAL ACCOUNTS IN THE ELECTRONIC ENVIRONMENT



Б.Золбоо

*ДХИС-ийн Сургалт судалгааны 403-р
анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн
албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн
тэнхимийн багш, хошууч*

Товч утга: Дэлхийн ихэнх улс орны эрх зүйн практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хяналт, хязгаарлалт тогтоох замаар ял эдлүүлэх нь хамгийн түрүүнд сонгон хэрэглэвэл зохих ял шийтгэлийн үндсэн хэлбэр гэж үзэж байгаа бөгөөд хорих ялыг зөвхөн хохирогчийн аюулгүй байдалд заналхийлсэн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн зэрэг цөөн тохиолдолд хэрэглэх учиртай гэсэн үзэл баримтлал, зарчим давамгайлж байна.

Ял эдлүүлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийж үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь их хэмжээний зардал үүсгэж байгаагийн зэрэгцээ суллагдсан хүмүүс нийгмийн орчинд дасан зохицох чадвар муу, гэмт хэрэг дахин үйлдэхээс үл эмээх хандлагатай байгаагаас үүдэн хорих ялыг үр дүн багатай ялын төрөлд тооцдог.

Шинэ төрлийн ял болох зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийж, санал, зөвлөмж боловсруулах нь эрүүгийн ялын зорилго, үр нөлөөг дээшлүүлэх, ял завших боломж олгохгүй байх, ял гарцаагүй байх зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Түлхүүр үг: Шийдвэр гүйцэтгэгч, дүн шинжилгээ, ял шийтгэл, эрх чөлөө

Abstract: In the legal practice of most countries in the world, it is considered that serving a sentence by imposing supervision and restrictions without isolating the offender from society is the main form of punishment that

should be used first and foremost, and the prevailing concept and principle is that imprisonment should only be used in a few cases, such as those that threaten the safety of the victim or commit extremely serious crimes. An analysis of the process of serving a sentence shows that serving a sentence in prison generates a lot of costs, and since those released have a poor ability to adapt to the social environment and are not afraid of committing crimes again, imprisonment is considered a type of punishment that is not effective.

Keywords: Decision-constructor, analysis, punishment, and freedom

НЭГ. ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ

Доктор, профессор Д.Баярсайхан “Харьцуулсан эрүүгийн эрх зүй” бүтээлдээ “Зорчих эрхийг хязгаарлах” гэсэн нэр томьёог судлан үзэхэд “зорчих” гэдэг нь хүн нэг зүгийг чиглэн зорчих, ийш тийш зорчин явах, “эрхийг хязгаарлах” гэдэг нь эрхийг нь багасгах, хэмжээ тогтоох гэсэн утга илэрхийлж байгаагаас дүгнэвэл хүний чөлөөтэй зорчих хөдөлгөөнийг хязгаарлах гэж үзэж болно. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 18 дахь хэсэгт заасан “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих” гэсэн иргэний эрхэд хязгаарлалт тогтоож байгаа нь уг ялын онцлог юм. Энэхүү ялыг “эрх чөлөө хязгаарлах”, “зорчих эрхийг хасах”, “гэрийн хорио” зэрэг хэд хэдэн нэршлээр томьёолсон. Тухайлбал, гэрийн нөхцөлд хорих ял нь 1984 оноос хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор тухайн этгээдийн амьдарч буй орон байранд нь хатуу хязгаарлалтын дор хорьж цагдах ял юм (Д.Баярсайрхан, 2012) гэж авч үзжээ.

Доктор, профессор Б.Алтангэрэл “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа” бүтээлдээ хорихоос өөр төрлийн ял шийтгэлийн асуудлаар 1990 онд Нэгдсэн үндэсний байгууллагаас “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” Токиогийн дүрмийг батлан гаргасан нь хорих ялаас татгалзах, хорихоос бусад төрлийн ял шийтгэлийг өргөн хэрэглэх нөхцөлийг зарчмын хувьд бүрдүүлсэн чухал дүрэм болсон билээ. Энэхүү дүрмийн гол онцлог нь эрх зүйн зөрчил үйлдсэн этгээдүүдийг нийгмийн хэвийн амьдралд түргэн эргэж ороход нь туслах, хорих ялаас татгалзах, ялын нөлөөг цээрлүүлэхээс ороход нь туслах, хорих ялаас татгалзах, ялын нөлөөг цээрлүүлэхээс илүүтэй дахин хэрэг зөрчил үйлдэж давтан гэмт хэрэгтэн болох явдлаас сэргийлж, төрийн эрх бүхий байгууллагын хяналтад авах замаар хүмүүжүүлж авахыг илүүд үзжээ (Б.Алтангэрэл, 2018).

Доктор, дэд профессор Э.Батбаяр “Хорихоос өөр төрлийн ял” нэг сэдэвт бүтээлдээ орчин цагт ял нь “хорих болон хорихоос өөр төрлийн ял” гэж зааглагдаж буй хандлага түгээмэл болсон учир зорчих эрхийг хязгаарлах ялыг хорихоос өөр төрлийн буюу нийгмээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тусгаарахгүй шинжтэй ялын тогтолцооны хүрээнд, “альтернатив” шинжийг нь харгалзаж, ялын бодлогын хувьд “хүний эрх, энэрэнгүй байх зарчимд үндэслэж, хорих ялаас татгалзах” явдлыг суурь гол үзэл санаа, баримтлал болгож, сонгох боломж бүхий ялаар хэргэлэх болсон байна (Э.Батбаяр, 2024) гэжээ.

Доктор, дэд профессор Я.Батгэрэл “Зорчих эрхийг хязгаарлах ялаас зайлсхийсэн ялтанд хүлээлгэх хариуцлага” илтгэлдээ зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэл нь хүмүүнлэг ёсны үзэл санаа давамгайлснаараа уг ялаар шийтгэгдсэн ялтандаа эдийн засгийн хувьд хэмнэлттэй байдлаараа улс эх орондоо давуу талыг олгодог бөгөөд орчин үеийн техник технологийн дэвшлийг ашиглан ялтан этгээдийн чөлөөтэй зорчих эрхэнд хязгаарлалт тогтоон, ялын мөн чанар, ялын зорилгыг хэрэгжүүлдгээрээ хүмүүнлэг энэрэнгүй нийгмийн сонгодог хэлбэрийг бүрдүүлдэг байна (ШШГЕГ, 2025) гэжээ.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг цээрлүүлэхээс гадна түүнийг нийгмээс бүрэн тусгаарлахгүйгээр засарч, хүмүүжих, зүй зохистой, зөв амьдралд ороход нь туслах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, өөрийгөө хөгжүүлэх, ажил хөдөлмөр эрхэлж гэр бүл, үр хүүхдээ тэжээн тэтгэх, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх боломжийг олгох, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгыг давхар агуулдаг.

Шүүх зорчих эрхийг хязгаарлах ялыг сонгож оногдуулахдаа гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруугийн хэр хэмжээ, хувийн байдал, бусдад учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хүний үндсэн эрх, журамт үүрэг, амин чухал хэрэгцээ шаардлагуудыг харгалзан “эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох”, “тодорхой газар очихыг хориглох”, “шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих” зэрэг хуульд нэрлэн заасан хязгаарлалтын аль нэгийг, эсхүл хэд хэдэн хориглолт, хязгаарлалтыг зэрэгцүүлэн хэрэглэх, түүнчлэн чөлөөтэй зорчих хязгаарлалтын бүсийг нэг, эсхүл хэд хэдэн дүүрэг, хороо, багийн нутаг дэвсгэрийн аль тохирох нэгжийг хамааруулан тогтоох боломжтойгоос гадна ялтныг бусдад аюул

учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй харилцахыг давхар хориглож болно.

Олон улсын баримт бичигт:

Токиогийн дүрэм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45/110 дугаар тогтоолоор “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” (Токиогийн дүрэм)-ийг 7 бүлэг 23 зүйлтэйгээр батлан гаргасан нь хорих ялаас татгалзах, хорихоос бусад төрлийн ял шийтгэлийг өргөн хэрэглэх нөхцөлийг зарчмын хувьд бүрдүүлсэн чухал зохицуулалт болсон.

Токиогийн дүрэм нь хорих ялын хэрэглээг багасгах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг хөгжүүлэх зорилго агуулж, нийгмийн болон хохирогчийн ашиг сонирхлыг хамгаалах, шаардлагатай тохиолдолд хохирогчтой зөвлөлдөж байхыг зөвлөжээ.

Энэхүү дүрэмд хорихоос өөр төрлийн арга хэмжээнд хэрэглэх дараах үндсэн зарчмуудыг тусгасан. (дүрэм, 1990) Үүнд:

-хорихоос өөр төрлийн ял эдэлж байгаа этгээдийн наад захын баталгааг хангах;

-эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хандах олон нийтийн идэвхтэй оролцоог хангах, нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг нь хөгжүүлэхэд дөхөм үзүүлэх;

-үндэсний эрүүгийн хууль тогтоомжийн бодлого, зорилтыг харгалзан хэрэглэх;

-гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын тухайд нийгмийн сонирхол, хохирогчийн эрх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх хоорондын зүй зохистой харьцааг хангах;

-хорих ял хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжоор хангах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нийгэмд, хэвийн амьдралдаа эргэж орох хэрэгцээ, шаардлага, хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн хууль тогтоомж дахь бодлогыг оновчтой болгох зорилгоор үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулах.

Дүрмийн гол зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг төрийн эрх бүхий байгууллагын хяналтад авах замаар хүмүүжүүлэх, нийгмийн хэвийн амьдралдаа эргэж ороход нь туслах, хорих ялаас татгалзах, ялын нөлөөг цээрлүүлэхээс илүү гэмт хэрэг дахин үйлдэж давтан гэмт хэрэгтэн болохоос сэргийлэхэд чиглүүлэх явдал юм.

Үүнээс гадна хорихоос өөр төрлийн арга хэмжээ нь үр дүнгээ өгч байгаа тохиолдолд уг арга хэмжээг хугацаанаас нь өмнө өөрчлөх, хүчингүй болгох, үр дүнд хүрээгүй тохиолдолд шууд хорих ял хэрэглэхээс зайлсхийн хорихоос өөр төрлийн арга хэмжээгээр солих зэрэг зохицуулалт санал болгосон байна.

Түүнчлэн хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий алба хаагч нь амьдралын туршлагатай, мэргэжлийн зохих бэлтгэлтэй, хувийн шинж чанараар тохирох хүн байвал зохино хэмээн тусгайлан тодорхойлсон.

Хорихоос өөр төрлийн арга хэмжээг сонгох бололцоотой нөхцөлд шүүн таслах эрх бүхий байгууллага дараах байдлаар шийдвэрлэж болохоор зохицуулсан. Үүнд:

- сануулах, зэмлэх, буруушаах зэрэг аман арга хэмжээ;
- хариуцлагаас тэнсэн чөлөөлөх;
- иргэний зарим эрхийг нь хасах;
- нэг удаагийн болон өдрийн торгууль зэрэг мөнгөн шийтгэл оногдуулах, эдийн засгийн арга хэмжээ авах;
- хөрөнгө хураах, эд хөрөнгө өмчлөх эрхийг нь хасах тогтоол гаргах;
- хохирогчид эд хөрөнгийг нь буцааж өгөх, хохирол төлөх тогтоол гаргах;
- тэнсэх, шийтгэлийг хойшлуулах;
- хорихоос тэнсэн суллах болон шүүхийн хяналт тогтоох;
- нийгмийн тустай хөдөлмөр хийлгэх тухай тогтоол гаргах;
- тодорхой газар нутагт заавал ирж бүртгүүлж байх болзол тогтоох;
- гэрийн хорионд байлгах;
- хорихтой холбоогүй бусад арга хэмжээ авах;
- дээр дурдсан арга хэмжээнүүдийг хослуулан хэрэглэх.

Дүрмийн заалтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хүний шашин шүтлэг, арьсны өнгө, нас, хүйс, хэл, улс төрийн болон бусад үзэл, нийгмийн гарал үүсэл, эд хөрөнгийн байдал, төрсөн газар зэргээр ялгаварлан гадуурхахгүйгээр хэрэглэнэ.

Мөн хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх явцад тухайн этгээд эрх нь зөрчигдсөн гэж үзвэл гомдол гаргах эрхтэй байхаар заасан байна.

ХОЁР. ЗОРЧИХ ЭРХ ХЯЗГААРЛАХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавина.

Ингэхдээ, ялтанд зорчих эрх хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журам, хяналтын техник, хэрэгслийг ашиглах, арчлах заавар, журам, ял эдлэх нөхцөл, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээний талаар тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн хүн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг хүлээх ба хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтын нөхцөлийг өөрчлөх, хязгаарлалт тогтоосон бүсээс гадагш түр зорчих, эсхүл удаан хугацаанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлага үүсвэл энэ талаарх хүсэлтээ хяналт тавьж буй эрх бүхий байгууллагын албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх боломжтой.

Зорчих эрхийг хязгаарласан ял шийтгүүлсэн ялтан дараах үүрэгтэй (Өмгөөллийн эрх зүй, 2024). Үүнд:

- Шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлэх;
- Шийдвэр гүйцэтгэгч, техникийн ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
- Шүүхээс тогтоосон зорчихыг хязгаарласан газарт зорчихгүй байх;
- Шийдвэр гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэхгүйгээр оршин суугаа газар, ажлын байраа өөрчлөхгүй байх;
- Шийдвэр гүйцэтгэгчийн тогтоосон хугацаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ирэх, ял эдлүүлэхтэй холбогдсон асуудлаар амаар болон бичгээр тайлбар гаргах;
- Тогтоосон журмын дагуу зөөврийн хяналтын төхөөрөмжийг биедээ байнга авч явах, бүрэн бүтэн байдлыг нь хангахад шаардлагатай бүх арга

хэмжээг авах, хяналтын төхөөрөмжийг хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

-Хувийн бичиг баримтаа биедээ авч явах;

-Ял эдэлж дуусмагц хяналтын тоног төхөөрөмжийг шийдвэр гүйцэтгэгчид бүрэн бүтэн хүлээлгэн өгөх зэрэг болно.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болж, ялтанд цахим бугуйвч зүүлгэсэн өдрөөс эхлэн тоолдог.

Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн дараах тохиолдолд прокурор ялтны зорчих бүсийг өөрчилж болно. Үүнд:

-Ялтны ар гэрийн байдалд өөрчлөлт орсны улмаас шүүхээс анхлан тогтоосон газарт ял эдлүүлэх боломжгүй болсон;

-Ялтны санхүүгийн чадавх, гамшиг, аюулт үзэгдлийн улмаас байнга оршин суугаа газраа өөрчлөх шаардлагатай болсон;

-Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ялтан оршин суух газраа өөрчлөх зорилгоор хувийн орон сууц, хашаа байшин худалдан авсан;

-Ялтны ял шийтгүүлэх үеийн хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон, эсхүл өөр байгууллага, хуулийн этгээдэд шилжин ажиллах, шилжин суралцах шаардлагатай болсон;


-Дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагад элсэн суралцах;

-Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүхээс тогтоосон бүсэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжгүй болсон зэрэг орно.


Ялтан ял эдлэх бүсээ өөрчлөх тухай үндэслэл бүхий хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтны хүсэлт, шийдвэр гүйцэтгэгчийн санал, холбогдох материалыг хянаж, 10 хоногийн дотор прокурорт хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

Ялтан зорчих эрхийн хязгаарлалтыг зөрчиж хяналтын бүсээс гарах, хориглосон газарт очих, уулзахыг хориглосон хүнтэй харилцах, техникийн хяналтын тоног төхөөрөмжийг устгах, гэмтээх, хэвийн ажиллагааг нь сарниулах, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэх, шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзах, эсэргүүцэх зэргээр ял эдлүүлэх журмыг ноцтой зөрчвөл зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааг хуульд заасны дагуу хорих ялаар солино.

Зураг 1. Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтаны тоо Улсын хэмжээнд авч үзвэл.



Зураг 2. Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтань тоо. Нийслэлийн хэмжээнд авч үзвэл.




Зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар сольж шийдвэрлэсэн шалтгаан нөхцөлийн талаар:

Тус ялыг хэрэгжүүлж эхэлснээс хойш 2021 онд 170, 2022 онд 496, 2023 онд 308, 2024 онд 242, үүнээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 168 дугаар зүйлийн 168.1-т заасан үүргээ 3 сарын хугацаанд 2, түүнээс дээш удаа биелүүлээгүй **273** ялтан, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн **108** ялтан, техникийн хяналтын тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, эсхүл тэдгээрийн хэвийн ажиллагааг сарниулах зөрчлийг давтан гаргасан **193** ялтан, техникийн болон биечилсэн хяналтаас 24 цагаас илүүгүй хугацаагаар санаатайгаар зайлсхийх зөрчлийг давтан гаргасан **221** ялтан, шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, хүч хэрэглэн эсэргүүцсэн, шийдвэр гүйцэтгэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан, хохирол учруулахаар заналхийлсэн **42** ялтан, техникийн болон биечилсэн хяналтаас 24 цагаас илүү хугацаагаар санаатайгаар зайлсхийх зөрчлийг давтан


гаргасан **379** ялтан нийт **1216** ялтны зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар сольж шийдвэрлүүлсэн байна (ШШГЕГ, 2024)

Зураг 2. Зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар сольж шийдвэрлүүлсэн байдал.



Дүгнэлт. Үүнээс хархад зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлсэнээр Монгол улсын ял шийтгэлийн бодлогод мэдэгдэхүйц ахиц дэвшил хэмнэлтийг авчирч байгаа бөгөөд тоон үзүүлэлтээс хархад цаашид ялын тоо буурах төлөвтэй байгаа нь харагдаж байна.

Зураг 3. Зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар сольж шийдвэрлүүлсэн байдал.



Шүүх тодорхой үндэслэл заахгүйгээр ялтны гадагш зорчихгүй байх хязгаарлалтын бүсийг хэт өргөнөөр буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хамгийн том нэгж болох аймаг, нийслэл, эсхүл сум, дүүргийн нутаг дэвсгэрээр хялбарчилж тогтоох, эсхүл хэт хумьж оршин суугаа баг, хорооны нутаг дэвсгэрээс, эсхүл оршин суух хаяг буюу гэрээсээ гарч

явахыг хориглох, түүнчлэн хязгаарлалт тогтоох нутаг дэвсгэрийн хүрээг шийдвэрлэхгүй орхигдуулах, хязгаарлалт тогтоох хугацааг оновчгүй тогтоох зэрэг алдаа зөрчил нь ял оногдуулах үндэслэл, журамд нийцэхгүйгээс гадна уг ялын зорилго, хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж болохыг хяналтын шатны шүүхийн тогтоолд дурдсан байна (гого, 2024).

ДҮГНЭЛТ

Зорчих эрхийг хязгаарлах ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр, хамт олон, гэр бүлийнхээ орчинд суралцах, хөдөлмөрлөх эрхийг нь ханган хэрэгжүүлж буйгаараа ихээхэн ач холбогдолтой байна.

Ял эдлүүлэх энэхүү ажиллагаанд хянах нийгэмшүүлэх ажлыг зөв хослуулж зохион байгуулснаар гэмт хэрэг дахин үйлдэх явдлыг бууруулахад чухал түлхэц болох юм.

Эдийн засгийн хувьд мөн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын цалингийн сангаар тооцон үзэхэд 2 тэрбум төгрөгийг сар бүр хэмнэж байгаа нь алба хаагчдын тоо болон эдийн засаг, цалингийн сангийн хувьд тодорхой хэмжээний хэмнэлт хийгдэж байгаа нь харагдаж байна.

Дэлхийн улс орнуудын шүүхийн практикт шүүхийн өмнөх, ял эдлүүлэх, хорих ял эдлээд хугацаанаасаа өмнө суллагдах үеүдэд зорчих эрхийг хязгаарлах арга хэмжээг сонгож хэрэглэдэг жишиг нэгэнт тогтжээ.

САНАЛ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 173 дугаар зүйлд “Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг түр өөрчлөхдөө прокурорын зөвшөөрснөөр ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтны зорчих эрхэд тогтоосон хориглолт, хязгаарлалтыг 30 хүртэлх хоногийн хугацаанд өөрчилж болно” гэж заасан нь ялтан гэнэт тохиолдсон (өвчилсөн, гэр бүлийн гишүүн нас барсан, байгалийн гамшиг, осол гэх мэт) асуудлаар ажлын бус өдөр, хэнд, хэрхэн хүсэлт гаргах нь тодорхой бус байх тул Прокурорын байгууллагатай нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатай байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны дахин болон өмнө үйлдсэн гэмт хэрэгт хорих, торгох, нийтэд тустай ажил хийлгэх зэрэг үндсэн ялыг тус тусад нь эдлүүлэхээр шүүх шийдвэрлэсэн тохиолдолд аль ялыг нь эхэлж эдлүүлэх талаар шүүхийн шийдвэрт энэ талаар тодорхой тусгах,

Цахим хяналтын сүлжээг сайжруулах, цахим бугуйвчний техникийн үзүүлэлтийг илүү боловсронгуй болгон хүртээмжийг сайжруулах.

Эх сурвалж

- Б.Алтангэрэл. (2018). In Б.Алтангэрэл, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа (p. 29). УБ.
- гого. (2024, 12). Retrieved from <https://gogo.mn/r/ydm7g> : <https://gogo.mn/r/ydm7g>
- Д.Баярсайхан. (2012). Харьцуулсан эрүүгийн эрх зүй. In Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эр зүй (pp. 248-249). УБ.
- дүрэм, Т. (1990). НҮБ-ын ерөнхий асамблэй . In Т. дүрэм, Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм.
- Өмгөөллийн эрх зүй. (2024). Retrieved from <https://advocate.mn/news/119/single/1972>: <https://advocate.mn/news/119/single/1972>
- ШШГЕГ, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны мэдээ судалгаа (12 2024).
- ШШГЕГ. (2025). Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. In ШШГЕГ, Зорчих эрхийг хязгаарлах ялын эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл (p. 193). УБ.
- Э.Батбаяр. (2024). Хорихоос өөр төрлийн ял. In Э.Батбаяр, Хорихоос өөр төрлийн ял (p. 129). УБ.